

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын мод тарих өдрийг “Хүн бүр байгаль хамгаалагч-Тэрбум мод- Байгалиа бүтээе” уриан дор сумын ОНХС-гийн хөрөнгөөр 3000 ширхэг хайлаас, 300 ширхэг улиас, 200 ширхэг агч, 200 ширхэг голт бор, 500 ширхэг жигд, 500 ширхэг гүйлс, 50 ширхэг өрөл, 58 ширхэг монос тус тус тарилаа. Сумын хэмжээнд 2023 оны хаврын тарилтаар нийт 4808 мод бут тарьсан.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “ХАЙР ЦАЦРУУЛСАН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. Баярын үеэр 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, OPEN MIK, 9-13 насныхны дугуйн уралдаан, “Тэр бөх хэний хэн бэ?” 4-5 настай хүүхдүүдийн барилгаан, талбайн зургийн уралдаан, өсвөр насны хүүхдүүдийн үндэсний шагайн харваа зэрэг уралдаан тэмцээн зохион байгууллаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулж байгаа Стратегийн команд штабын сургуулийн хүрээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 06 дугаар сарын 08-ны 16:00 цагт зохион байгууллаа. 16.00 цагт зарлан мэдээллийн дохио дуугарч сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн болон онцгой комиссын гишүүд цугларлаа. 84 хүн цуглахаас мэргэжлийн ангийн 23, онцгой комиссын 5 хүн нийт 28 хүн оролцож 33,3 хувийн ирцтэй оролцлоо. Зарлан мэдээллийн дохио дуугарахад иргэд “суу, нуугд, хүлээ” гэсэн дүрмийг баримталж бат бөх ширээн доогуур орж бие болон толгойгоо халхлан аюулгүй байдлаа хангаж, хоёр дахь дохио дуугарахад анги хамт олноороо толгойгоо халхлан яарч сандралгүй нэгийн цуваанд орж баруун гар талаа барьж, “гүйхгүй, эргэж буцахгүй, нэгнээ түлхэхгүй” гэсэн дүрмээ баримталж, байгаа газраасаа гарч, аюулгүй талбай буюу сумын төвд талбайд цугларлаа. Нийт 17 том хүн, 42 хүүхэд, нийт 62 иргэн дадлага сургалтад хамрагдсан.

6 дугаар сард E-mongolia оператороос 4 иргэн лавлагаа мэдээлэл авсан байна. Сумын вэб хуудсанд цаг үеийн болон сарын ажлын мэдээ, нийт 1 удаа мэдээлэл оруулсан.

2023 оны 06 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3489, өрх 1004, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 40, нас барсан 6 хүн бүртгэгдсэн.

Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд эрсдэлийн программд бүртгэлтэй 166 хүүхдийн шилжсэн-13, насанд хүрсэн-16, эрсдэлгүй- 25 эдгээр хүүхдүүдийг хасалт хийж үлдсэн 112 хүүхдийн ар гэрт эрсдэлийн үнэлгээ хийж программд шивэлт хийн тайланг Сүхбаатар аймгийн Гэр бүл , Хүүхэд Залуучуудын хөгжлийн газарт хүргүүлээд байна.

2023-2024 хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдах 2018 оны 80, 2019 оны 79, 2020 оны 77, 2021 оны 83, 2022 оны 66 нийт 385 хүүхдийн судалгааг гаргаж хүргүүлсэн.

2023 оны 06 дугаар сарын 23-ний байдлаар нийт 15 зээлдэгч байгаа ба хугацаа хэтэрсэн чанаргүй 6 зээлдэгч хэвийн 9 зээлдэгч байна. Зээлийн нийт үлдэгдэл 147,955,396 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн нийт төлсөн зээл 68,613,734 төгрөг байна.

ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

06 дугаар сарын 8-нд төсөвт байгууллагуудын сарын төсөв, гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөөний гүйцэтгэл, бусад мэдээ мэдээллийг шилэн дансанд шивж оруулсан.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн. Орон нутгийн ерөнхий орлого, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд шивсэн. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх ажлуудаас “Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл”- 71,0 сая төгрөгийн ажил 100% хийгдэж, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авч, ашиглалтад орууллаа. Хогийн цэгт хог асгах шинэ нүх ухуулах ажлын тендерт “Мандах оройн товгор” ХХК шалгарч, ажил 40% гүйцэтгэлтэй явж байна. Ажлын явцын хяналтыг өдөр бүр тавьж ажиллаж айна. Хүүхдийн цэцэрлэгийн гадаах тоглоомын талбайн тоглоомыг нэмэгдүүлэх бараа худалдан авах ажиллагаанд “Интерворлд” ХХК шалгарч, бараа нийлүүлэх гэрээ байгуулагдсан.

Долоо хоног бүрийн Даваа гарагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг программд тогтмол оруулж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/317 тоот “Хагас жилийн малын түүвэр тооллого явуулах тухай” захирамжийн дагуу” сумын Засаг даргын 2023 оны А/59 тоот захирамжийн дагуу хагас жилийн мал тооллогын ажлыг амжилттай зохион байгуулж дуусгалаа.

Хагас жилийн малын түүвэр тооллогын, бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих комиссыг 13 бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулав.

Мал тооллогын комиссын гишүүд болон тооллогын 5 группын ахлагч болон карт хөтлөгч нар болон багийн засаг дарга нарт нэгдсэн сургалтыг 05 дугаар сарын 29 өдөр зохион байгуулж аймгийн тооллогын комиссын сургалт семинараар өгсөн үүрэг, чиглэлийн талаар төрийн сангийн мэргэжилтэн сургалтыг зохион байгууллаа.

Сумын тооллогын комисс хуралдаж тооллогын үед хийх ажлын төлөвлөгөөг гарган баталж хариуцан ажиллах хүмүүсийг үүрэгжүүлсэн.

Хагас жилийн мал тооллогын түүвэрт сумын хэмжээнд 138 өрх, 1 ААНБайгууллага сонгогдсон байна. Мал тооллогын ажилд нийт 1395920 төгрөгийн зардал гарсан.

Мал тооллогын үед гарсан хүндрэл: 2023 оны 05 сарын 19 өдөр болсон цасан шуурга Түвшинширээ сумын нутгийг хамарсаны улмаас малын хорогдол их гарсан, мал уруудсан учраас малчин өрхүүд малын эрэлтэй, айл өрх эзгүй байх явдал их байна. Мөн малын хорогдлын мэдээг бүрэн гүйцэд авах боломжгүй, төл малын хорогдол нийт гарсан төлийн 30 хувийг эзэлж байна.

Багийн дарга нар нь 5 сарын төл, хорогдлын мэдээний өрхөөр авсан жагсаалт, хагас жилийн мал тооллогын мөл төллөлт, хорогдлын мэдээний тархаалтын нэмэлт тодруулгыг хийж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлж ажиллалаа.

ЗДТГ-ын албан хаагч өөрсдийн хүнсний хэрэгцээнд 0,5 га газарт төмс, хүнсний ногоо тариаллаа. ОНХС-с трактор, анжис худалдан авч хүнсний ногоо тариалах талбайг хагалж төмс, лууван, шар манжин, хүрэн манжин, сонгино зэргийг тариаллаа.

Төмс, өргөн хэрэглээний хүнсний ногоо тариалдаг 7 иргэн, 2 ААН байна. Төмс 0,6 га-д, хүнсний ногоо 0,235 га –д сумын хэмжээнд тариалаад байна. Цаг үеийн нөхцөл байдлаас хамааран хүнсний ногоог хожуу тариалсан. Хүнсний ногоо болон ногоон байгууламжийг услах хуваарь гарган, хуваарийн дагуу усалгааг тогтмол хийлгэж байна.

Адапт төсөлд сумаас нэг төсөл шалгарлаа. Өлзийт багийн “Таван атга “ малчдын бүлэг нь малын тоо толгойг тодорхой хэмжээнд бууруулан, бэлчээрийн доройтлоос хамгаалах зорилгоор зохистой ашиглах, сумын Засаг даргатай 15 жилийн хугацаатай Улаан толгой орчимд 2750 га талбай бүхий, өвөл, хаврын бэлчээр ашиглах гэрээ байгууллаа. Дэлгэрхаан багийн “Дэлгэрхангай “ малчдын бүлэг нь “Хургыг бага насанд нь нэмэлт тэжээлээр бордон зах зээлд борлуулах” төсөл бичин шалгарсан ба адапт төслөөс санхүүжилт аван ажиллах юм. Уг төслийн хүрээнд бүлгийн малчид малын тоо толгойг тодорхой хэмжээнд бууруулан, бэлчээрийн доройтлоос хамгаалах зорилгоор зохистой ашиглах, сумын Засаг даргатай 15 жилийн хугацаатай Дэлгэрхаан уулын зүүн урд хэсэг орчимд 2096 га талбай бүхий, өвөл, хаврын бэлчээр ашиглах гэрээ байгууллаа. Адапт төслөөр 2023 онд суманд 1 худаг, Өлзийт багийн Сэвхүүлийн булгийг хашиж хамгаалах ажилууд хийгдэнэ.

ХАА-1, ХАА-2 мэдээг статистикийн программ, хөдөө аж ахуйн программд мэдээг сар бүр шивж оруулж байна. Төл ,том малын хорогдлын мэдээг хөдөө аж ахуйн /live.stock.mofa.mn / - д өрхөөр шивж оруулж байна.

Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газрын улсын байцаагчийн 2023 оны 10-28-01/109/01 тоот “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх” тухай зөвлөмжийн дагуу Түвшинширээ суманд үйл ажиллагаа явуулдаг 4 цайны газраар баг гаран зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Тус ажлын хүрээнд дөрвөн цайны газрын хоёр нь албан ёсны зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг ба хоёр нь зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг байна. Улсын байцаагчийн зөвлөмж дээр заасан шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулдаг газар байхгүй байсан ба бүх цайны газрын ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан дэвтэр байхгүй, зориулалтын усны савгүй, ундны ус болон малын гарал үүслийн бичиг байхгүй, эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэмд нийцүүлсэн дотоод хяналтын баталсан дүрэм журам байхгүй байсан зэрэг маш олон зөрчил гараад байна. Уг асуудлын хүрээнд ажлын хэсэг улсын байцаагчийн зөвлөмжид заасан заавар зөвлөгөөг хүргүүлэн ажиллалаа.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

“Эх үрсийн баяр”-аар сургуулийн багш ажилчдын “Эцэг эхийн зөвлөл”-өөс санаачлан сургуулийн багш ажилчдын хүүхдийг хүлээн авч тэмцээн уралдаан зохион байгууллаа. Мөн сурын хүүхдийн дунд сургуулийн зүгээс тэмцээн уралдааныг зохион явууллаа. Сумын Засаг дарга түүний тамгын газраас 2022-2023 оны хичээлийн жилд

аймаг бүсийн олимпиад, уралдаан тэмцээнд амжилт гаргасан доорх сурагчдад шагнал бэлэг гардууллаа.

ЕБСургуулийн захирлын 2023 оны А\09 дугаарт тушаалаар сургуулийн анги дэвших болон төгсөх шалгалтын комиссыг багш, суралцагч, эцэг эх, сургуулийн удирдлага гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж 5-р сарын 25-наас 6-р сарын 8-ныг хүртэл анги дэвших 19 шалгалт, төгсөх 11 шалгалтыг зохион байгуулж, 1-2 дугаар ангийн сурагчдаас бусад бүх суралцагчид хамрагдлаа.

9, 12 дугаар анги төгсөх сурагчдын “Мөнгөн хонхны баяр” төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Аймаг бүсийн олимпиад, уралдаан тэмцээнд амжилт гаргаж сурлага, урлаг, спортоор бусдыгаа манлайлсан сурагчдыг шагнаж урамшууллаа.

2023 оны “Элсэлтийн ерөнхий шалгалт”-д тус сумын 21 суралцагч 7 төрлийн хичээлээр давхардсан 50 шалгалтад орж улс аймгийн дундажаас дээгүүр шалгагдаж аймагтаа 5 дугаарт эрэмбэгдлээ.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Монгол Улсын Соёлын яамнаас үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих, иргэдийг соёлын боловсролыг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “СОЁЛЫН СЭРГЭЛТ- 2023” аяныг Түвшинширээ суманд 6 дугаар сарын 08-нд зохион байгуулагдсан. Аяны хүрээнд “Амар Оюуны хөрөнгө оруулалт” төвийн илтгэгч “Үндэсний нэгдмэл үнэт зүйл, эв нэгдэл” сэдвээр илтгэл тавьж, хүүхэд залуучуудын театрын уран бүтээлчид болон сумын соёлын биет бус өв өвлөн уламжлагч, соёлын төвийн дугуйлангийн сурагчдын хамтарсан урлагийн тоглолтоо үзэгч ард олондоо өргөн барилаа. Мөн Сумын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарын гар урлалын сур суран эдлэл, гэрийн модон тавилга, сийлбэрийн бүтээлүүд болон “Орон нутаг судлах музей”-н нээлттэй үзүүллээ.

“Энэ жилдээ – Эрүүл жиндээ” аяны хүрээнд Улаанбаатар хотоос Монголын нийтийн бүжгийн холбоо “Ирээдүй” бүжгийн клубын багшийг урьж иргэд, албан хаагчдад цэнгээнт бүжгийн сургалт зохион байгуулан ажиллалаа.

Соёлын төвийн дэргэдэх нийтийн номын сан нь энэ сард 26 хүүхэд, 9 том хүнд ном олгох үйлчилгээг үзүүлж ажилласан. Соёлын сэргэлт-2023 аяны хүрээнд нутгийн зохиолчдын номны үзэсгэлэн гаргаж 113 хүүхэд 97 том хүн үзэж сонирхсон байна.

2023 оны 5-р сарын 30-аас 6-р сарын 12-ны хугацаанд “Эзэнт гүрний өв соёл” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Оорцог ууланд ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль, Чингис хаан үндэсний музей, Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн хамтарсан судалгааны баг археологийн малтлага

судалгааны ажил хийж гүйцэтгэв. Энэ удаагийн малтлагаар 2 дурсгалт газарт 8 дурсгал сонгон малтлага хийсэн болно.

Чингис хааны өв соёлын хүрээлэн, Чингис хаан Үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтнууд ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 80 гаруй сурагчдад “Чингис хаан үндэсний музей” байгуулагдсан түүх, “Эзэнт гүрний өв соёл” төслийн товч үр дүн, “Чингис хааны өв ба Монголчуудын соёл” сэдвээр тусгай лекц хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ДДЭШ компанийн 15 жилийн ойн баяр бүх нийтийн соёлын боловсролыг түгээн дэлгэрүүлэх соёлын хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор ЕБС-ын 6-12 ангийн хүүхэд багачуудад Монголын уран сайхны “ Дурсамж 2012” , “Шазам” зэрэг кинонуудыг толилууллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 146, алсын дуудлага 7, гэрийн дуудлага 5, хэвтэн эмчлүүлэгч 19, халдвартай бүсэд хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй.

Сар болгон хийгддэг товллын вакциныг 54 хүүхдэд хийгээд байна. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа улаанбурхан улаануудийн эсрэг вакцинжуулалтад нийт 536 хүүхэд хамрагдаад байна.

6 дугаар сард сэргээн засах эмчилгээнд: Бумба – 46, УВЧ – 33, Бариа -38, Гэрэл– 45 иргэнд үйлчилсэн.

Тухайн сард лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 11, үе мөч-11, шээсний ерөнхий шинжилгээ – 45, элгэний В, С вирус– 8, БЗХӨ –15, бруцёллөз-5, ковид-27 шинжилгээ тус тус хийгдсэн байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг рүү 5 удаа цэрний сорьцыг тээсэн.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг